

үйлдлийг сахилгын төрөлд тооцон хариуцлага хүлээлгэдэг практик түгээмэл байна.

2. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд боловсруулагдаж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ялтанд оногдуулах сахилгын зөрчлийг нарийвчлан тодорхой тусгаж өгөх. /жишээ нь: Зарим сахилгын зөрчил гаргасан ялтанд хуулиар олгогдсон эрхийг хязгаарлах/

**М.ЦЭНД**

*Оросын Холбооны
Улсын Дотоод явдлын
яамны Москвагийн их
сургуулийн адъюнкт,
хурандаа*

ХОРИХ БАЙГУУЛЛАГАД ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

Технологийн хөгжлийн өнөө үед хорих байгууллага дахь гэмт явдлын тухай асуудал нь зөвхөн хорих байгууллагын ажилтнууд, эрдэмтэн судлаач нарын төдийгүй олон нийт, сэтгүүлчдийн анхаарлыг татаж байна. Хорих байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг нь хорих ял эдлүүлэх төрийн бодлого, хорих ял эдлүүлэх үйл ажиллагааг эсэргүүцэн, байгууллагын аюулгүй байдал, хэвийн ажиллагаанд аюул занал учруулж байдаг юм. Хорих байгууллагад үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, арга механизм, оролцогчдын онцлог, сонирхол, хувийн сэдэл, дахин давтан үйлдэгдэж болзошгүй эсэх, шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зэргийг бүхэлд нь авч үзэж судлах шаардлагатай юм.

Хорих байгууллагад үйлдэгдсэн гэмт явдал гэдэг нь нийтээс тусгаарлан шүүхээс оногдуулсан ял шийтгэлийг эдлүүлэх явцад хорих ангийн аюулгүй байдал, хэвийн ажиллагааг тасалдуулж, бусдад гэмт аргаар халдаж хохирол учруулсан үйлдэл юм. Хорих байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг нь ялтнууд хоорондын, ялтан албан хаагч хоорондын, ялтнуудын бүлэглэл хоорондын харилцааны зөрчлөөс болж үүссэн байдаг.

Гэмт явдлын субъектив шалтгаан нь ялтнуудын санаархал, хувийн үзэл бодол, байр суурь, итгэл үнэмшил, үнэт зүйлээ хамгаалах хүсэл зорилго, хувийн шунахай сэдэлтээр илэрнэ. Объектив шалтгаан нь тэдгээрийн харилцааны зөрчилөөс үүдэлтэй байдаг. Энд ялтнуудын далд

д/д	2009	2010	2011	2012	2013
Үйлдсэн гэмт хэргийн тоо	19	18	9	24	24
Гэмт хэрэг үйлдсэн ялтны тоо	28	21	16	26	28
Хүний амь нас хохироосон					1
Хүний эрүүл мэндэд гэмтэл учруулсан	4		2	10	14
Хулгай хийсэн	2		2		2
Залилан					1
Хүчин				1	
Оргосон	14	10	12	15	4

буюу өвөрмөц зан үйлийн хэвшлийн тухай асуудлыг хамааруулан ойлгож болох юм. Объектив нөхцөл гэдэг нь ялтныг гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн бодит нөхцөл байдлыг хэлнэ. Энэ нь объектив шалтгаантайгаа ямагт уялдаж байдаг.

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь үйлдэгдэж болзошгүй гэмт явдлыг илрүүлэх, үйлдэгдсэн гэмт явдлыг бодитой

шалган баримтжуулж шийдвэрлэх, шалтгаан нөхцөлийг тогтоож, дахин давтан үйлдэгдэхээс сэргийлэх цогц арга хэмжээний систем юм.

Оросын эрдэмтэн М.Н.Гернет "Шоронгийн сэтгэл зүйн тэмдэглэлүүд" бүтээлдээ "шоронгийн гэмт явдлыг оргох болон бэлгийн хүчирхийлэл гэсэн 2 төрөлд ангилан үзэж болох юм" гээд сэтгэц зүйн талаас нь судалгаа шинжилгээ хийсэн байна. Минийхээр бол дээрхи ангилал учир дутагдалтай юм. Зөвхөн бэлгийн хүчирхийлэл бус бусад төрлийн хүчирхийлэл, дарамтыг хамруулан авч үзвэл зохино.

Г.Ф.Хохряков, Г.С.Саркисов нар "Хорих байгууллагад үйлдэгдэж буй гэмт явдлын объект нь гэмт явдлыг үйлдэж буй ялтнууд, тэдгээрийн хүрээлэн буй орчин юм"¹⁶³ гэжээ.

Оросын эрдэмтэн Ю.М.Антонян "Хорих газарт хүч хэрэглэсэн гэмт хэрэг ихээр үйлдэгддэг бөгөөд ихэнхдээ гэмт хэрэгт тооцогдож бүртгэгдээгүй байдаг юм. Ялтнуудын 20-35% нь хүмүүсийн анхаарлыг өөртөө хандуулах гэсэн сэтгэцийн өөрчлөлт бүхий хүмүүс

байдаг. Тэдгээр нь хүмүүсийн эд зүйлийг дээрэмдэж, хүч хэрэглэж, объектийн аюулгүй байдалд байнга заналхийлж байдаг Иймд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бүх л төрлийн цогц арга хэмжээнээс гадна сэтгэц заслын арга хэмжээнд хамруулж байх нь зүйтэй юм" гэжээ.

¹⁶³ Хохряков Г.Ф Саркисов Г.С "Преступления осужденных: причины и предупреждение: / Основные проблемы пенитенциарной криминологии / Ереван, 1988. С.32-33 и др.; Хохряков Г.Ф. Парадоксы тюрьмы. М., 1991; Хохряков Г.Ф. Социальная среда, личность и правосознание осужденных: / теория и методика криминологического исследования/. Дис. ...докт.юрид. наук. М., 1987.

Он	2009	2010	2011	2012	2013
Ажил хийхээс зайлсхийсэн	5	2	3	8	6
Ажлын байр хорих ангиас дур мэдэн явсан	11	4	8	2	9
Бусдыг дарамталж эд зүйлс булаасан	12	21	18	30	34
Бие эрхтэндээ санаатай гэмтэл учруулсан		8	5	4	9
Архи уусан	74	87	246	179	132
Хориотой тоглоом тоглосон	18	6	33	31	23
Албан хаагчийн тавьсан хууль ёсны шаардлага эсэргүүцсэн	107	98	88	92	111
Гар утас	520	621	1097	1304	1436
Бүгд	1030	1101	1795	1956	2082

"Хорих байгууллагад үйлдэгдэж буй гэмт явдал нь тэнд оршин буй нууц далд дэг жаяг, уламжлал, зан заншил, ялтны бүлэглэлүүдийн өрсөлдөөнөөс

үүдэн гардаг"¹⁶⁴ гэж эрдэмтэн О.В. Старков бичсэн байна. "Хорих байгууллага чанга хатуу хяналт, хамгаалалттай байхад гэмт хэрэг үйлдэх нь хэцүү. Гэхдээ үүнийг хамгийн аюултай гэмт хэрэгтнүүд ялтнуудын дунд өөрийнхөө карьерыг өсгөхийн тулд үйлдэж байдаг"¹⁶⁵ хэмээн Францын эрдэмтэн Ж.Пинатель бичжээ. Мөн эрдэмтэн В.Н. Бурлакова, В.П. Сальникова нар нь "Хорих байгууллагын гэмт явдалд ялтан хоорондын сөргөлдөөнөөс гадна орон нутгийн цаг агаар, байгалийн хүнд нөхцөл, албан хаагч нарын зүй бус харьцаа, албаны мэдлэг сул, ёс зүй дорой, ялтантай хувийн харьцаа тогтоож байгаа явдал нь

нөлөөлж байна"¹⁶⁶ гэж бичсэн байна. Энэ нь манайд ч бас анхаарвал зохих асуудал юм.

Манай хорих ангиудад 2009-2013 онуудад үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн талаархи баримт судалгааг харья.

Дээрхи судалгаанаас үзэхэд ялтнаас үйлдсэн зөрчлийн тоо жил дараалан өсч, гэмт хэргийн гаралт, тэдгээрийг үйлдэгчдийн тоо буурахгүй байгаа нь харагдаж байна.

Хорих байгууллагад гэмт явдлаас урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээ гэж юуг хэлэх вэ, яавал

¹⁶⁴ Старков О.В. Пенитенциарная преступность и ее закономерности в СССР и России// Человек: преступление и наказание. Рязань. 1996. № 3-4. С. 16.

¹⁶⁵ Pinatel J. La Criminologie. Paris, 1969. P.158-163.

¹⁶⁶ Криминология. Учебник. Под ред. В.Н. Бурлакова, В.П. Сальникова, С.В. Степашина. СПб, 1999. С. 430-432.

үр дүн гарах вэ гэдэгт бид анхаарал хандуулах цаг болжээ. Нийгмийн ажил, тоо бүртгэл, сэтгэл зүйн эмчилгээ, дэглэм, хяналт, харуул хамгаалалт, гүйцэтгэх ажил, эмчлэн сувилах ажлууд бүгд харилцан уялдаа хамааралтай явагдаж, ялтны талаархи мэдээллүүдийг харилцан солилцож, ангийн удирдлага болон албадуудыг мэдээллээр хангах нь чухал юм. Харилцан мэдээлэл солилцсоноор ялтнуудын дунд зохиох ажлын тактик боловсруулахад чухал ач холбогдолтой бөгөөд урьдчилан сэргийлэх ажлын гол цөм болно. Одоогийн байдлаар манай ихэнхи алба хаагчид хамтран ажиллаж, харилцан мэдээлэл солилцохгүй байна. Ялтнуудын гал, бүлэглэлийг тараах, саармагжуулах, тэдний дунд нөлөө бүхий ялтнуудын үйлдлийг таслан зогсоох, нийт ялтны сэтгэл санааг өргөх, гэмт санаа бодлоос татгалзуулах, хүмүүжлийн нөлөөлөл үзүүлэх ажлыг түлхүү зохион байгуулах, гэмт хэрэг үйлдэж болзошгүй байгаа ялтнуудыг харуул хамгаалалтын болон гүйцэтгэх ажлын тасралтгүй хяналтанд авах гэх мэтээр харилцан уялдаатай ажиллаж байж урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж чадна. Мөн албан хаагчдын албан үүргээ ухамсарлах үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, ач холбогдлыг нь ойлгуулах, шинэ төрлийн гэмт хэрэг жишээлбэл хар тамхи-ийн талаар мэдээлэл өгөх хэрэгтэй.

Хорих байгууллагын гэмт явдлын тухай судлахын тулд тэдний дундаас лидерүүд буюу нөлөө бүхий рецидивист ялтнууд төрөн гарах үзэгдэл, тэдний хүрээлэн буй гэмт орчныг судлах нь зүйтэй. Тэд хаанаас хэрхэн яаж бий болдог вэ. Тэднийг хэн

хүмүүжүүлж, хэн бэлтгэдэг вэ. Ялтнуудын дунд ямар уламжлал дэг жаяг тогтсон байна вэ, тэднийг рецидивист гэмт хэрэгтэн болгон төлөвшихөд түлхэц өгч буй ямар орчин нөхцөл тэнд байна вэ, Бусад ялтнуудад тэдний үзүүлэх нөлөө, дарамтыг хэрхэн бууруулах, сармагжуулах вэ гэдгийг нарийн тооцон төлөвлөх нь чухал. Өөрөө бусдаас илүү гэдгээ харуулж, бусдыг айлган сүрдүүлж дарамтлах замаар эрхшээлдээ оруулан авдаг ялтнуудыг "Овгор" гэж яриад байдаг¹⁶⁷. Хэсэг бүлэг хүмүүс түүнийг өргөмжлөн гаргах, эсвэл өөрийгөө зарлан тунхаглах арга замаар овгор этгээд гарч ирдэг. Тэдний нөлөөг бууруулж, тараан бутаргаж, гэмт үйлдлээсээ сайн дураар татгалзуулахад хүргэх гэх мэт арга хэмжээг гүйцэтгэх ажил, харуул хамгаалалт, нийгмийн ажлын чиглэлээр тасралтгүй зохион байгуулж байх шаардлагатай болдог.

Хорих байгууллагад гэмт явдлаас урьдчилан сэргийлэх аргуудыг ерөнхий, бүлгийн тусгай арга хэмжээ гэж ангилан үзэж болох ба эдгээр арга хэмжээнүүд бүгд нийлж бүхэлдээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээ болох юм. Эдгээр арга хэмжээнүүдийг тус тусад нь авч үзье.

Хорих байгууллагад гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ерөнхий аргууд:

-Ялтны бүрэлдэхүүний талаар дүн шинжилгээ хийх

-ШШГЕГ-аас хорих ангиудад дэглэм, харуул хамгаалалт, нийгэмшүүлэх, гүйцэтгэх ажлын, эмнэлгийн, ахуй хангалтын гэх мэт

¹⁶⁷ Беляцкий Н.П. Основы лидерства / Учебное пособие. – Минск, 2002. – С.61.

чиглэлүүдээр хяналт, шалгалт хийх, үйл ажиллагааны доголдлыг илрүүлэх

-Хорих байгууллагын нөхцөл байдал, үйл ажиллагааны талаар хөндлөнгийн хяналт буюу прокурорын шалгалт хийх

-Алба хаагчдын өдөр тутмын албан үүрэг гүйцэтгэж буй байдалд үнэлэлт дүгнэлт өгөх

-Холбоо дохиолол хяналтын үйл ажиллагааны доголдлыг илрүүлэх

-Ялтны бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөх бүрт ялтны дундах эрүүгийн нөхцөл байдалд судалгаа хийж, дүгнэлт өгөх

-Ялтны дунд оршин байгаа үл зохилдох үзэгдэл, бие биенээ дэглэх, дарамтлах гаж оролдлогуудыг илрүүлэх

-Ялтанд чиглэсэн бүх л ажлыг идэвхижүүлэх

-Дээрхи ажилд урсгал байдлаар хандаж байгаа алба хаагчдыг тогтоож, засч залруулах арга хэмжээ авч, үүрэг чиглэл тодотгон өгч байх

-Ялантай хувийн харьцаа тогтоосон албан хаагчдыг илрүүлэн олж холбогдох шийдвэр гаргаж байх

-Албаны шаардлага хангаж чадахгүй байгаа албан хаагчдын асуудлыг шийдвэрлэх

Дээрхи нөхцөл байдлыг тодорхойлохын тулд холбогдох мэдээллийн эх сурвалж заавал хэрэгтэй юм. Тийм учир зайлшгүй шаардлагатай мэдээллийг дараах эх үүсвэрээр олж авч боно. Үүнд:

-Холбогдох бичиг баримтуудад дүгнэлт хийх

-Ялтан болон тэдний төрөл төрөгсдийн өргөдөл, гомдол, мэдээлэл, хүсэлт, захидал

-Ялтныг биечлэн хүлээн авч, уулзсан ярилцлагын тэмдэглэл

-Хорих байгууллагын статистик мэдээлэл

-Ялтны үйлдсэн гэмт хэрэг, зөрчилд албаны шалгалт хийсэн материал

-Ялантай хувийн харилцаа тогтоосон албан хаагч болон бусад этгээдүүдэд албаны шалгалт хийсэн тухай материал

-Дотоодын төлөвлөгөөт болон гэнэтийн шалгалтын материалууд

-Ялтны хувийн хэрэг

-Албан хаагч болон албадуудын илтгэх хуудас

-Ялтнууд гэм буруугаа хүлээсэн материал

-Ялтны дунд явуулсан гүйцэтгэх ажлын арга хэмжээний үр дүнгийн тухай илтгэх хуудас

-Ялтны бие байр, эд зүйл, амьдралын бүс, үйлдвэрлэлийн талбайд үзлэг нэгжлэг хийсэн болон эргэлт уулзалт, илгээмжээр хүлээн авсан эд зүйлсэд үзлэг хийсэн тухай илтгэлүүд

-Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзан хаасан материалууд

-Ялтны талаар гүйцэтгэх алба болон бусад албадаас гаргасан тодорхойлолтууд

-Ялтны биед учирсан гэмтэлийн талаархи эмнэлгийн албаны тодорхойлолт

-Харуул хамгаалалтын албаны болон хуяглан хүргэгч харуулуудын илтгэлүүд

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар гаргасан албан хаагч, ялтнууд, иргэд, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын саналууд

-Ялтны дунд үйлдэгдэж буй гэмт явдлын талаар хийсэн криминологи судалгааны ажлын үр дүн, албан хаагчдын хуралдааны тэмдэглэл

ОХУ-ын эрдэмтэн И.В. Каретников хорих ангийн эрүүгийн нөхцөл байдал, хорих ангийн дэглэм журмыг зөрчигдөхөд нөлөөлж буй хүчин зүйлүүдийн тухай мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх "Дохио" нэртэй систем санаачлан боловсруулсан байна. Өдөр бүр мэдээлэл цуглуулж, цаг хугацааны хувьд, нөлөөлж буй хүчин зүйлүүдийн хувьд гэх мэтээр ангилан ялгаж тэдгээрийг судлан шинжилж, хорих байгууллагын үйл ажиллагааны доголдолд нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлснээр гэмт явдлаас урьдчилан сэргийлэх систем бий болгож чаджээ.

Хорих байгууллагын үйл ажиллагааны доголдлын улмаас гэмт явдалд хүргэх нэгэн том хүчин зүйл нь алба хаагчидтай холбоотой асуудлууд юм. Энэ чиглэлээр дараах ажлууд хийх шаардлагатай юм.

-Албан хаагчдын боловсрол, мэдлэг, чадвар, дадлага, арга барилын түвшинг тасралтгүй дээшлүүлж байх

-Хорих байгууллагын сэтгэл зүй, сурган зүйн онцлог, ялтны сөргөлдөөн, өрсөлдөөн, маргаан, тэдгээрийг зохицуулах

-Албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөгдөх эрх зүйн актын мэдлэг, тэдгээрийг хэрэглэх чадварыг шалгах

-Ажилдаа идэвхитэй хандах хүсэл сонирхолыг дээшлүүлэх, тэдний сахилга хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх

Хорих байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахын тулд:

-Ялтнуудад байнгын тасралтгүй хяналт тавьж байхаар харуул хамгаалалтын үйл ажиллагааг зохион байгуулах

-Өдрийн цагийн хуваарийг хатуу мөрдүүлэх

-Хориотой эд зүйл дамжуулах, нэвтрүүлэх сувгийг хаахын тулд үзлэг нэгжлэгийг чанартай зохион байгуулах, шалган нэвтрүүлэх харуулаар дамжин өнгөрч байгаа тээврийн хэрэгсэл, ялтнууд, албан хаагчдад хийх үзлэг, хяналтыг сайжруулах

-Хэрэг хам, гал хамууд, бүлэглэлүүдийг тараан байрлуулах, зөрчил гаргасан, түүнд хамтран оролцсон ялтнуудыг тараан байрлуулах, нэг дор бөөгнүүлэхгүй байлгах, тэднийг ажил хөдөлмөрт гаргахдаа салган хуваарилах

-Ялтнууд амьдралын болон үйлдвэрлэлийн бүс, байр, бусад объектуудын хооронд дураараа сэлгүүцэх явдлыг таслан зогсоох

-Ялтанд тасралтгүй хяналт тавих орчин үеийн телекамер, бусад техник хэрэгслийг ашиглаж байнга сайжруулж байх

-Ялтны захидал илгээмж, автомашин шалгах техник хэрэгсэл, рентген төхөөрөмж ашиглаж байх

-Ялтны дундаас үйлдэгдсэн болон үйлдэгдэж болзошгүй гэмт явдлыг шалган баримтжуулах, илрүүлэх, таслан зогсоох болон бусад төрлийн тусгай ажиллагааг зохион байгуулахад ангийн алба хаагчдын хүчин хүрэлцэхгүй тохиолдолд бусад ангитай хамтран ажиллаж байх

-Ялтны дунд нийгэмшүүлэхээс гадна сурган хүмүүжүүлэх, хүмүүжлийн нөлөлөл үзүүлэх ажлыг түлхүү зохион байгуулж энэ ажилд олон нийтийн байгууллагын туслалцааг ашиглах

-Ялтанд сахилгын шийтгэлийг зөв, шударга ноогдуулах

-Эрх зүйн суртал ухуулгын ажил зохион байгуулах

-Ялтны ерөнхий боловсролын болон мэргэжлийн сургалтуудад хамрагдах хүсэл, сонирхол, идэвхи оролцоог нэмэгдүүлэх

-Албад бүрийн хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах

Гүйцэтгэх ажлын доголдлыг арилгахын тулд:

-Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа болон ялтнуудын хоорондох өрсөлдөөн, сөргөлдөөний тухай мэдээллийг тогтмол авч байх, чанаржуулах

-Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж буй тухай мэдээллийг бусад алба, ажилтнуудад тухайн цагт нь шуурхай, цаг алдалгүй өгч сэрэмжлүүлж, анхааруулах, хяналт тавьж хамтран ажиллах

-Цаг тухай бүрт нь эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгах

-Гэмт хэргийн тухай мэдээллийг олж илрүүлэхийн тулд гүйцэтгэх ажлын арга хэмжээг нарийн төлөвлөн хэрэгжүүлж байх

-Ялтнуудыг гэмт үйлдлээсээ татгалзахад хүргэх нөхцөл байдал бий болгох

Ялтныг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх бүлгээр хэрэгжүүлэх арга хэмжээ:

-Ялтныг стресс тайлах, сэтгэц зүйн зөвлөлгөө өгөх, сэтгэцийн эмчилгээ хийх, нийгэмшүүлэн дэмжлэг үзүүлэх, хүмүүжлийн нөлөөлөл үзүүлэх, эмнэлэгийн асаргаа сувилгаа хийлгэх гэх мэт хэсэг бүлэг болгон ангилж тусгай төлөвлөсөн ажил зохион байгуулах

-Гэм нүглийг наманчлуулах, бурханд сүсэглүүлэх, залбируулах

-Спортын уралдаан тэмцээн зохион байгуулах

-Хорих ангийн захиргаанаас анхаарал хандуулж шаардлагатай дэмжлэг үзүүлэх. Дээрхи арга хэмжээг хэн нэгэн албан тушаалтан дангаараа хэрэгжүүлж чадахгүй бөгөөд хорих ангийн бүх албан хаагчид, нарийн төлөвлөгөөний дагуу хамтран хэрэгжүүлэх ёстой юм.

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээ.

ОХУ-ын эрдэмтэн Пахомов В.Д., Волобуев А.Н., Киреев М.П нар "Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлын тусгай арга хэмжээ нь ялтныг судлахаас эхэлнэ. Хувийн хэрэг, эрүүгийн хэрэг, намтар түүх, урьд ажиллаж байсан газрын тодорхойлолт, эмнэлгийн өвчний түүх, алба хаагчдын түүний талаар гаргасан тодорхойлолтууд, шалгасан материалууд гэх мэт бичиг баримтуудыг судлан тусгайлан бэлтгэсэн анкет бөглөж, түүний зан чанарын өөрчлөлтийн талаар график гаргана"¹⁶⁸ гэжээ.

Ялтнууд болон албан хаагч, ялтнуудтай холбоотой этгээдүүдээс тусгайлан бэлтгэсэн анкет, санал асуулгын хуудсаар судалгаа хийнэ. Үүний дараа ялтнуудыг хориотой тоглоом тоглогсод, хорих ангийн дэглэм журмыг санаатайгаар зөрчигсөд, сэтгэцийн өөрчлөлттэй хүмүүс, хорих ангиас оргогсод, хорих ял эдэлж байхдаа гэмт хэрэг үйлдэгчид, хорих анги шилжин ирэгсэд, спирт, хар тамхи, мансууруулах бодис хэрэглэгчид, байнга оршин суух газаргүй, хөдөлмөрөөс зайлсхийдэг, хүч хэрэглэгчид, гомосексуалистууд гэх

¹⁶⁸ Пахомов В.Д., Волобуев А.Н., Киреев М.П. и др. Профилактика побегов из мест лишения свободы: Метод. рекомендации. М., 1988. С. 48.